“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2020 оны 06 дугаар сарын 15 — Багануур дүүрэг

| № | Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Шалгуур үзүүлэлт | 2020 онд хүрэх түвшин, үр дүн | Хэрэгжил-тийн хувь | Үнэлгээ-ний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **НЭГ. ЭДИЙН ЗАСАГ, ЭРХ ЗҮЙН ШИНЭ ОРЧИН БҮРДСЭН ХОТ** | | | | | | | |
| **Эдийн засаг, төсөв санхүүгийн чиглэлээр:** | | | | | | | |
| 18 | **1.10. “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын үйл ажиллагааг эрчимжүүлнэ.** | 1.10.1. Батлагдсан зураг төсвийн дагуу ажлыг эрчимжүүлнэ. | БҮТП ОНӨТҮГ, ДБҮҮХ | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | | |
| | | 1. Паркийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл Барилга хөгжлийн төвд магадлангаар хянагдан баталгаажсан. Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлын хувьд БҮТП-ийн Газрын дарга нь цахилгаан хангамжийн техникийн нөхцөл авах ажлыг эрчимжүүлэн БХБЯ, БХТ, ЭХЯ, Диспетчерийн үндэсний төвтэй уулзалт зохион байгуулан техникийн нөхцөлд тулгамдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн зөвлөсний дагуу Багануур 220/110/35 кв-ын дэд станцийн 110 кв-ын талаас хангуулахаар “Диспетчерийн үндэсний төв” ХХК-аар цахилгаан хангамжийн горим ачааллын тооцоог гүйцэтгүүлэн 2020.05.27-нд хүлээн авсан. Мөн “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Зүүн Өмнөд бүсийн салбарын холбогдох инженер техникийн ажилтнуудтай уулзалт хийж цахилгаан хангамжийн холболтын схем болон хэрэглээ ачааллын гаргалгааг зөвшилцөв. Зураг төслийн төсвийг Барилга хөгжлийн төвийн техникийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж, нэгдсэн дүгнэлт гаргуулахаар бэлтгэж байна. | | | | **93** | |
| | | 2. БОАЖЯ-ны Байгаль орчны үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хуралдаан 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулагдаж, “Санни трейд” ХХК-ийн гүйцэтгэсэн “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдөр хүлээн авсан. дэд бүтцийн барилга байгууламж, үйлдвэр баригдаж эхлэхэд орчинд үүсэх өөрчлөлтийн мониторингийг хэрэгжүүлэх аргачлалыг боловсруулахаар бэлтгэж байна. | | | | **100** | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 3. 2020 оны Нийслэл болон Улсын төсвөөс Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад санхүүжилт тавигдаагүй боловч Паркийн удирдлагын зүгээс хөрөнгө оруулалт татах ажлыг эрчимтэй зохион байгуулан ажиллаж байна. Эхний ээлжинд байгуулах чухал шаардлагатай Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн өндөр хүчдэлийн 7,3 км агаарын шугамын төслийн саналыг хөрөнгө оруулагч нарт санал болгосноор "МЕСЕС" ХХК-иар гүйцэтгүүлэхээр 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр БҮТП, МЕСЕС болон Мон-энержи Консалт ХХК хамтын ажиллагааны гурвалсан гэрээг байгуулан ажиллаж байна. Эхний ээлжинд шаардлагатай бүх зардлыг тус компани гаргаж 110/35/10 кВ-ын 7,3 км цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн агаарын шугамыг байгуулж, паркийн эзэмшилд бүрэн шилжүүлэн өгөх юм. Паркийн зүгээс дээрх зардлын 50%-ийг Нийслэлийн төсвийн тодотголоор оруулах санал тавьж, дүүргийн болон нийслэлийн Засаг дарга нарын хэмжээнд урьдчилсан байдлаар шийдвэрлүүлсэн.<br>4. 04 дүгээр сард Газрын дарга нь цахилгаан хангамжийн техникийн нөхцөл авах ажлыг эрчимжүүлэн БХБЯ, БХТ, ЭХЯ, Диспетчерийн үндэсний төвтэй уулзалт зохион байгуулан техникийн нөхцөлд тулгамдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн зөвлөсний дагуу Багануур 220/110/35 кв-ын дэд станцийн 110 кв-ын талаас хангуулахаар "Диспетчерийн үндэсний төв" ХХК-аар цахилгаан хангамжийн горим ачааллын тооцоог гүйцэтгүүлэн 2020.05.27-нд хүлээн авсан. Мөн "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн Зүүн Өмнөд бүсийн салбарын холбогдох инженер техникийн ажилтнуудтай уулзалт хийж цахилгаан хангамжийн холболтын схем болон хэрэглээ ачааллын гаргалгааг зөвшилцөв. 2020.06.09-ний өдөр ЭХЯ-д дээрх ЦДАШ-ыг байгуулах тухай техникийн нөхцөл цахим хэлбэрээр хүсэж холбогдох материалуудыг оруулав. Мөн хөрөнгө санхүүжилтийн төслийг 2020.06.03-ны өдрийн А/102 дугаартай албан бичгээр НЗД-д, мөн өдрийн А/100 тоот албан бичгээр Дүүргийн Засаг дарга нарт уламжлан хүргүүлэв. | 30 | |
| | | 5. Паркийн Үйлдвэрийн албан конторын барилгын гадна болон дотор инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулагдаж, дүүргийн хангагч байгууллагуудтай зөвшилцөн магадлалаар хянагдан баталгаажсан. Зураг төслийн нэгдсэн дүгнэлтийг гаргуулахаар бэлтгэж байна. | 93 | |
| | | Дундаж хувь | 79% | |

УЛААНБААТАР ХОТ БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГазар УГ 00614 ... 2715 109064

БИЕЛЭЛТ ХЯНАСАН:
"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН: Б.НОМИНЗУЛ